

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ-3 ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

2019 оны 11 сарын 14-д батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг хангах үүднээс холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэн өөрчлөх хэрэгцээ шаардлага үүсэж байна. Нэмэлт, өөрчлөлтийн нэг томоохон хэсэг нь шүүх эрх мэдлийг бэхжүүлэхэд чиглэсэн гурван заалт бөгөөд энэ хүрээнд шүүхийн тухай хууль тогтоомжид өөрчлөлт орох юм.

2020 оны 1 сарын 31-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудсанд Шүүхийн тухай хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлалын хамт нийтлэгдэж олон нийтийн саналыг авч эхлээд байна. Нээлттэй Нийгэм Форумын Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд энэхүү чухал бодлогын баримт бичигт ул суурьтай, судалгаанд суурилсан санал шүүмж өгөх нь зүйтэй гэж үзлээ. Энэ зорилгоор шүүх эрх мэдлийн хүрээнд бодлогын судалгаа хийж байсан туршилагатай хуульч, судлаачдын төлөөлөлтэй зөвлөлдөж, холбогдох харьцуулсан судалгаа, дүн шинжилгээний дүнд үндэслэн энэхүү хуулийн шүүмжийг боловсруулан гаргалаа.

Шүүхийн тухай хуулийн төсөл нь одоогийн үйлчилж буй Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай болон Шүүхийн иргэний төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг нэгтгэн багтааж боловсруулагдсан тул өргөн хүрээний агуулгыг хамарсан болно. Иймээс энэхүү хуулийн шүүмжийг Шүүхийн тухай хуулийн үзэл баримтлал, Шүүгчийн сонгон шалгаруулалт томилгоо, Шүүхийн ерөнхий зөвлөл гэсэн тодорхой сэдвийн хүрээнд цувралаар гаргаж бодлого боловсруулагчдын анхааралд хүргэхийг зорилоо.

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ХЭСЭГТ ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Шүүхийн захиргааны тухай бие даасан хуулийг Шүүхийн тухай хуульд нэгтгэн оруулж, тус хуулийн төслийн 14-р бүлэгт зохицуулжээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүргийг дараах байдлаар шинэчлэн ангилж бүлэглэсэн байна.

5-р зүйл. Ерөнхий Зөвлөлийн чиг үүрэг:

5.1.1. шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах;

5.1.2. шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах;

5.1.3. шүүгчийг хуульчдаас шилж олох;

5.1.4. шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

5.1.5. шүүхийн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх.

72-р зүйл. Ерөнхий зөвлөл, түүний чиг үүрэг

72.2. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

72.2.1. захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх;

72.2.2. шүүхийг хүний нөөцөөр хангах; 72.2.3. шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

72.2.4. шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах;

72.2.5. мэдээллээр хангах.

Санал: Шүүхийн тухай хуулийн төслийн 70.1-р зүйлд шүүхийн захиргааны бүрэлдэхүүнд судалгааны институцийг оруулаагүй Дээд шүүхийн харьяанд байхаар (тус хуулийн 24.1-р зүйл) заажээ. Тэгвэл хуулийн төслийн 70.2-р зүйлд ШЕЗ-ийн үндсэн чиг үүрэгт ... мэдээлэл, судалгааны туслалцаа үзүүлэх, 72.2.5-р зүйлд мэдээллээр хангах, улмаар 77-р зүйлд мэдээллээр хангах чиг үүргийг дэлгэрүүлэн тусгасан хэдий ч ямар бүтэцтэй хэрэгжүүлэх талаар зохицуулалт байхгүй байна. Иймд ШЕЗ-өөс шүүх, олон нийтийг мэдээллээр хангах чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх цогц үйл ажиллагааг ямар бүтцээр дамжуулан хэрэгжүүлэхийг тодорхой болгож, шүүхийн судалгааны дэд институцийн харьяаллыг өөрчилсөн үндэслэлийг тодорхой тусгах нь зүйтэй.

Нэг. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно” гэж нэмэлт өөрчлөлт оруулжээ. Үүний дагуу Шүүхийн тухай хуулийн төсөлд ШЕЗ-ийн зөвлөлийг бүрдүүлэх журмыг дараах байдлаар тусгажээ:

Шүүхийн захиргааны тухай хууль	Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл
13.1. ... Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг анхан шатны шүүхийн шүүгчдийн болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, Хуульчдын холбооноос нэг, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг хүний нэрийг тус тус санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.	78.2. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос /цаашид “Байнгын хороо” гэх/ гурав, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс хоёрыг тус тус нээлттэйгээр нэр дэвшүүлж томилох бөгөөд ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох таван шүүгчийг Шүүгчдийн зөвлөлөөс нууцаар санал хураан сонгосон Улсын дээд шүүх, давж заалдах шатны шүүхийн тус бүр нэг, анхан шатны шүүхийн гурван шүүгч тус тус орно.

Хуулийн төслийн §78.2-т Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч бус 5 гишүүнийг дан ганц улс төрийн байгууллага, албан тушаалтнаас буюу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс томилохоор тусгасан нь учир дутагдалтай.

Дагаж мөрдөж буй Шүүхийн захиргааны тухай хуулийн дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлсэн өнгөрсөн хоёр удаа (2013, 2016 он)-гийн процессоос үзэхэд уг ажиллагаа нь цэвэр түүний үзэмжийн хүрээнд шийдвэрлэгдэж байсан. Иймд хэдийгээр хуулийн төслийн §79.2-т хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг томилох журмыг тусгасан ч энэ нь бодит байдал дээр хэлбэрийн төдий явагдах магадлалтай юм. Харин эсрэгээрээ 2013, 2017 онд болсон Монголын Хуульчдын холбооноос Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг тодруулах ажиллагаа өрсөлдөөн ихтэй (олон хүн нэрээ дэвшүүлдэг), нээлттэй ил тод үйл ажиллагаа байсан.

Санал: Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч бус 5 гишүүний хоёрыг Монголын Хуульчдын холбооноос сонгохоор төсөлд тусгах нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаанд нийцнэ. Ингэхдээ нэгэнт 5 шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох тул Монголын Хуульчдын холбооноос Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг сонгох ажиллагаанд Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны оролцоог байхгүй болгож, Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчөөс бус, нээлттэйгээр нэр дэвшүүлсэн хүмүүсээс Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүдийн нууц санал хураалтаар сонгодог байхаар хуулийн төсөлд тусгах.

Хоёр. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шүүхийн захиргааны тухай хууль	Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл
<p>16.1. Ерөнхий зөвлөлийн гишүүн дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>16.1.1. Монгол Улсын иргэн байх;</p> <p>16.1.2. хууль зүйн дээд боловсролтой;</p> <p>16.1.3. мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;</p> <p>16.1.4. ял шийтгүүлж байгаагүй;</p> <p>16.1.5. шударга зан чанар, өндөр ёс зүйтэй;</p> <p>16.1.6. шүүгчид нэр дэвшигчийн мэдлэг, ур чадвар, туршлагыг аливаа нөлөөнд үл автан бодитой үнэлэх чадавхтай байх.</p> <p>§16.2. Ерөнхий зөвлөлийн дарга энэ хуулийн 16.1.1, 16.1.2, 16.1.4-16.1.6-д заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>16.2.1. мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх;</p> <p>16.2.2. удирдах ажлын дадлага, туршлагатай байх.</p>	<p>78.3. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч нь таваас доошгүй жил ажилласан, бусад гишүүд нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.</p> <p>20.6. Шүүгчээр 5 жил ажиллаагүй, сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэшлийн болон Сахилгын хорооны гишүүнээр сонгохгүй.</p>

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 5 гишүүнд тавигдах шаардлагыг тодорхой болгож иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагад ажилладаг эрх зүйч, хуульчдын оролцоог нээхэд анхаарах нь зүйтэй. Учир нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх хугацаанд органик хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнд хууль зүйн сургуулийн үндсэн багш, Хуульчдын холбоо, эсхүл иргэний нийгмийн гишүүдээс оруулдаг байх үзэл санаа маш олон давтагдаж байсан юм.

Санал:

- Шүүхийн захиргааны тухай хуульд байгаа “шударга зан чанар, өндөр ёс зүйтэй”, “шүүгчид нэр дэвшигчийн мэдлэг, ур чадвар, туршлагыг аливаа нөлөөнд үл автан бодитой үнэлэх чадавхтай байх” зэрэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хэвээр үлдээх. Ингэснээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох гишүүд нь хуулийн энэхүү шаардлагыг хангасан эсэх талаар хэлэлцэх, хэлэлцүүлэг өрнүүлэх, нээлттэй нэр дэвшүүлэлтийн хүрээнд нэр дэвшигч нь уг шаардлагыг хангасан эсэх талаар хөндлөнгийн комисс, ажлын хэсэг дүгнэлт гаргах боломж бүрдэнэ.
- Шүүхийн ерөнхий зөвлөлд орох шүүгч бус 5 гишүүний шаардлагад “сүүлийн 6 жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байх” гэсэн шаардлагыг нэмж тусгах. Ингэснээр Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс улс төртэй төдийлөн холбогдож байгаагүй хүнийг томилоход эергээр нөлөөлнө гэж үзэж байна.
- Шүүхийн ерөнхий зөвлөлд орох шүүгч бус 5 гишүүний шаардлагад “шүүгчээр болон сүүлийн 6 жилийн хугацаанд шүүхийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд ажиллаж байгаагүй байх” гэсэн шаардлагыг нэмж тусгах. Шүүхийн ерөнхий зөвлөлд орох шүүгч бус 5 гишүүнд ийм шаардлага тавихгүй бол шүүгч байсан эсхүл шүүхийн захиргааны байгууллагад удирдах албан тушаалд ажиллаж байсан хүн томилогдох магадлалтай болох бөгөөд энэ тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 10 гишүүнийг шүүхийн болон шүүхийн бус төлөөллөөс тэнцвэртэй бүрдүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа алдагдахад хүрч болзошгүй.
- Хуулийн төслийн §20.6-д тусгасан “Шүүгчээр 5 жил ажиллаагүй, сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэшлийн болон Сахилгын хорооны гишүүнээр сонгохгүй” гэсэн заалт нь хууль зүйн техникийн хувьд тухайн институцийн бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг тусгасан хэсэгт орохоор байгааг анхаарах.

Гурав. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ

Санал:

- Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг сонгох санал хураалтыг нууцаар явуулах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах. Энэ нь тус байнгын хорооны гишүүд хараат бусаар үндэслэл бүхий итгэлээрээ саналаа өгөх баталгаа болно.
- Хуулийн төслийн §79.3-т “Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг зөвхөн Шүүгчдийн зөвлөлийн төлөөлөгчид дундаасаа нэр дэвшүүлэх”-ээр хязгаарласан нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, тухайн шүүгч Шүүгчдийн зөвлөлийн хуралдаанд оролцоогүй (тухайн шүүгч нь Шүүгчдийн зөвлөлийн хуралдаанд оролцож чадахгүй хүндэтгэн үзэх шалтгаантай байж болно) гэдгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхийг нь хязгаарлах нь оновчгүй тул Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн болох хүсэлтэй, хуульд заасан шаардлагыг хангасан шүүгч бүр чөлөөтэй нэрээ дэвшүүлэх боломжийг олгох нь зүйтэй.

Дөрөв. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙГ ДУУСГАВАР БОЛГОХ

Шүүхийн захиргааны тухай хууль	Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл
<p>19 дүгээр зүйл. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, огцруулах</p> <p>19.1. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө:</p> <p>19.1.1. бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;</p> <p>19.1.2. тэтгэврийн насанд хүрсэн болон эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;</p> <p>19.1.3. өөрөө хүсэлт гаргасан болон өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон;</p> <p>19.1.4. Ерөнхий зөвлөлийн гишүүнд санал болгосон шүүгчдийн хамтарсан зөвлөгөөн болон Хуульчдын холбоо, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эгүүлэн татах шийдвэр гаргасан.</p> <p>19.2. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр огцруулна:</p> <p>19.2.1. хуралдааныг удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан;</p> <p>19.2.2. ёс зүйн ноцтой алдаа гаргасан;</p> <p>19.2.3. гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон.</p>	<p>84 дүгээр зүйл. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, огцруулах, эгүүлэн татах</p> <p>84.1. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө:</p> <p>84.1.1. бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;</p> <p>84.1.2. тэтгэврийн насанд хүрсэн болон эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;</p> <p>84.1.3. өөрөө хүсэлт гаргасан болон өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон.</p> <p>84.2. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр огцруулна:</p> <p>84.2.1. хуралдааныг удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан;</p> <p>84.2.2. ёс зүйн ноцтой алдаа гаргасан;</p> <p>84.2.3. гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>84.3. Шүүгчдийн зөвлөл энэ хуулийн 84.2-т заасан үндэслэлээр шүүгчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээс эгүүлэн татна.</p>

2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр зарим шүүгчээс шүүгчийн хараат бус байдлыг хангах талаар ажиллахгүй байгаа, мөн өөрсдөө шүүгчийн хараат бус байдалд халдсан үйл ажиллагаа явуулж байна хэмээн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн хамтарсан зөвлөгөөнөөс нэр дэвшиж томилогдсон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг эгүүлэн татах асуудлыг хэлэлцүүлэх хүсэлтийг “Монголын Шүүгчдийн холбоо” ТББ-ын Удирдах зөвлөлд ирүүлж байсан.¹ Тухайн үед Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг эгүүлэн татах процессын асуудлыг хуульд тодорхой зохицуулаагүйгээс шалтгаалан шүүгчдээс гаргасан уг хүсэлт хэлэлцэгдээгүй. Мөн 2016 оны 8 дугаар сард Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчөөс өөрийн санал болгож томилуулсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн нь шүүгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах талаар хуульд заасан үүргээ биелүүлж ажиллахгүй байна” гэсэн үндэслэлээр эгүүлэн татах саналыг Ерөнхийлөгчид гаргасан боловч Ерөнхийлөгчийн зүгээс шийдвэр гаргаагүй.²

Санал:

- Дээрх кейсүүд нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг огцруулах, эгүүлэн татах эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг харуулж байна. Иймд хуулийн төсөлд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг огцруулах, эгүүлэн татахтай холбоотой процедурын асуудлыг нарийвчлан журамлаж тусгах (саналыг хэн гаргах, хэрхэн хэлэлцэж шийдвэрлэх гэх мэт), мөн хуулийн төслийн §84.3-т Шүүгчдийн зөвлөлөөс сонгосон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг эгүүлэн татахыг зохицуулсан хэр нь УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс томилсон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг эгүүлэн татах асуудлыг зохицуулаагүй нь ойлгомжгүй байгааг анхаарч шүүгч бус 5 гишүүнийг огцруулах, эгүүлэн татах асуудлыг мөн адил нарийвчлан тусгах.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг огцруулах, эгүүлэн татахтай холбогдуулж зайлшгүй байх нэг чухал асуудал бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний баримтлах ёс зүйн хэмжээг тогтоох явдал юм. ШЕЗ-ийн гишүүний ёс зүйн үүрэг, зарчим, хориглолтыг хуульчилж өгөх замаар тэдгээрт тавих ёс зүйн наад захын төвшнийг тогтоох хэрэгтэй. Харин бусад зохицуулалтыг хуулийн төслийн §78.9-д зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрэмд тусгах нь зүйтэй. Ёс зүйн дүрмийг Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө батлах нь бие даасан байдлынх нь нэг баталгаа болно.

¹ Дэлгэрэнгүйг эндээс үзнэ үү. <http://judge.mn/home/view?pid=119> сүүлд 2020.02.07-нд хандсан.

² Дэлгэрэнгүйг эндээс үзнэ үү. <https://www.mglbar.mn/news/1411> сүүлд 2020.02.07-нд хандсан

БУСАД АСУУДАЛ

Хуулийн төслийн §79.6-д “Нөхөн сонгогдсон буюу томилогдсон Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн хугацаатай адил байна” гэсэн гэж оновчгүй байна. Учир нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн арван гишүүний бүрэн эрх нэгэн зэрэг дуусгавар болж дараагийн арван гишүүн шинээр томилогдож байх нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын залгамж чанарыг алдагдуулахаар байна.

Санал: Иймд хуулийн төслийн §79.6 дахь хэсгийг хасах.

Шүүхийн захиргааны тухай хууль	Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл
18.1. Ерөнхий зөвлөлийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.1.6. Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, шүүхийн тамгын газрын даргад нэр дэвшүүлэх;	82.1. Ерөнхий зөвлөлийн дарга нь гишүүний бүрэн эрхээс гадан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 82.1.6. Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, шүүхийн тамгын газрын даргад нэр дэвшүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах;

Санал: Шүүхийн ерөнхий зөвлөл нь хамтын удирдлагатай байгууллага байтал төслийн §82.1.8-д зааснаар зөвхөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргад “Ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Улсын дээд шүүхээс бусад шүүхийн тамгын газрын даргад сахилгын шийтгэл ногдуулах” бүрэн эрхийг олгосон нь оновчгүй тул Шүүхийн захиргааны тухай хуулийн байгааг §18.1.6 дахь заалтыг хэвээр хадгалах.

ХУУЛИЙН ШҮҮМЖ БОЛОВСРУУЛСАН БАГ:

П.БАТТУЛГА, “Оюуны-Инновац” эрх зүйн судалгааны ТББ-ын судлаач, хуульч
Б.ТӨРБОЛД, “Оюуны-Инновац” эрх зүйн судалгааны ТББ-ын судлаач, хуульч
О.МӨНХСАЙХАН, Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн профессор
А.БЯМБАЖАРГАЛ, Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор
Б.ГҮНБИЛЭГ, Хууль зүйн ухааны доктор, хуульч судлаач
Н.БААСАНЖАВ, Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн харууцлагын хорооны тэргүүн, хуульч
П.БАДАМРАГЧАА, Нээлттэй Нийгэм Форумын Эрх зүйн хөтөлбөрийн менежер



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn